

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
 ГАЗРЫН 2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**  
 /2018.06.16-2018.07.25/

2018 оны 07 дугаар сарын 25

Замын-Үүд сум

№	Бүтээгдэхүүний нэр	Биелэлт
1	2	3
<b>Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр</b>		
1	Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.	Дорноговь аймаг дахь газраас тайлант хугацаанд албадан гаргасан гадаадын иргэн байхгүй болно.
2	Монгол Улсад байх, буцах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилгоосоо өөр төрөл ангиллын визтэй зорчиж буй гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг нарийн тогтоож материал бүрдүүлэн ажиллах	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6, Засгийн Газрын 2010 оны 338 дугаар тогтоолын 4.1-ийн дагуу Монгол улсад байх, буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй 2 орны 44 иргэнийг улсын хилээр оруулалгүй буцаан ажилласан.
3	Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллана.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 2 орны 9 иргэнийг 660.0 мянган төгрөг, 10 аж ахуйн нэгж байгууллагын 24 иргэнд 1,230.0 мянган төгрөг, 2 уригч иргэний урьсан 2 иргэнийг 20.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
4	Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах	Тайлант хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулаагүй болно.
5	Замын-Үүд авто зам, төмөр замын боомтоор зорчиж байгаа гадаадын иргэдэд орох, гарах-орох, дамжин өнгөрөх виз олгох	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн Газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 9 орны 81 иргэнд зохих зориулалт, ангиллын визийг олгож, визийн хураамж болох 6,296.0 мянган төгрөг, визийн үнэ болох 562.4 мянган төгрөгийг төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлж ажилласан.
1	2	3

6	Виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэн, бүртгэл хөтөлж, мэдээллийн санд баяжилт хийх	Зөрчил гарган, арга хэмжээ авагдсан БНХАУ-ын 16 иргэн, гарцаагүй байдлын улмаас /хил орчмын нутаг дэвсгэрт үймээн самуун гарсан/ хил нэвтэрч чадалгүй байх хугацаа хэтрүүлсэн тул торгуулиас чөлөөлөгдөн бүртгэл, хасалт хийлгэсэн БНХАУ-ын 2 иргэн, бүртгэлийн хугацаа нь ажлын бус өдөр дууссан байсан тул ГИЭЗБТХ-ийн 43.3-г үндэслэн БНХАУ-ын 1 иргэн, оршин суух зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр хасалт хийж, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 29 иргэн, ОСЗ авалгүй 21 хоногтоо нутаг буцахаар түр ирэгчийн бүртгэлд хасалт хийлгэсэн БНХАУ-ын 3, нийт гадаадын 2 орны 51 иргэнд хасалт хийж Монгол Улсаас гаргасан болно.
<b>Хоёр. Захиргаа, удирдлага, хүний нөөцийн чиглэлээр</b>		
7	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас хайрцаг/ дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт байхгүй болно.
8	Хуурамч баримт бичиг, түүний таних заавар, Тамга тэмдэг ашиглах, хуурамчаар баримт үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Хилийн 0108-р ангид 2018 оны 07 дугаар 18-ны өдөр албан бичгээр Хуурамч баримт бичиг, түүний таних заавар, Тамга тэмдэг ашиглах, хуурамчаар баримт үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт оруулах хүсэлт гаргасан ба хилийн цэргийн санаачлагаар сургалтыг түр хугацаагаар хойшлуулсан болно.
9	Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах	“Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-иар 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдөр газрын захиргааны мэргэжилтэн сургалт зохион байгуулж сургалтаар гэр бүлийн хүчирхийлэл түүнээс үүсэх үр дагаврын талаар албан хаагчидад зохих мэдээ мэдээллийг олгож сургалтанд нийт 8 хаагч хамрагдсан.
<b>Гурав. Санхүүгийн чиглэлээр</b>		
10	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах	Тайлант хугацаанд батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 37,701.6 мянган төгрөгийн санхүүжилт орсноор 31,866.5 мянган төгрөгний зарлага гаргасан. Үүнээс цалин хөлс 26,012.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 3,143.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2,711.2 мянган төгрөгийг зарцуулан ажилласан.

1	2	3
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган харилцах дансаар хийгдсэн 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ болон бусад мэдээллийг хуулийн хугацаанд нь шилэн дансны сайтад шивж байршуулсан. Мөн 06 дугаар сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн тайланг 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.
12	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах	Төсвийн гүйцэтгэлийн 06 дугаар сарын мэдээ болон үнэт цаасны тайланг 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Замын-Үүд төрийн сангаар хянуулан Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мөн 2018 оны 06 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гаргаж албан хаагчдын дэвтэрт бичилт хийн, нийгмийн даатгалын цахим сайтад шивж, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан.
<b>Дөрөв . Дотоод хяналт, аюулгүй байдлын чиглэлээр</b>		
13	Албан хаагчдыг гадаад улсад зорчиход холбогдох дээд шатны нэгжид мэдэгдэх	Гадаад улсад зорчсон албан хаагчдын бүртгэлийг хөтөлж, тайлангийн хугацаанд газрын 4 албан хаагчаас хувийн ажлаар 4 удаа БНХАУ-ын Эрээн хотод зорчих талаар урьдчилан мэдэгдсэн байна.